



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**МАНДАЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМД**

2024.08.07 № ГНАГ-2024/13-МТА-НА-28
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн

018020966

тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгосон.

Дүгнэлт

Ардчилсан намын Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мандал сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр (.....¹² хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Мандал сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

МАНДАЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР



ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН
ЭРЧИМТ ХӨГЖЛИЙН ШИНЭЧЛЭЛ

2024 он

ТОВЧ УТГА

Нэг. Иргэний эрх, нийгмийн баталгаа

- 1.1 Гэр бүл, хүүхэд
- 1.2 Тусгай хэрэгцээт иргэд
- 1.3 Ахмад, эмэгтэйчүүд, залуучууд
- 1.4 Боловсрол
- 1.5 Эрүүл мэнд
- 1.6 Соёл урлаг, спорт

Хоёр. Хүний эрх, эрх чөлөө

Гурав.Хэвлэл мэдээлэл

Дөрөв.Тогтвортой хөгжил, эдийн засгийн өсөлт

- 4.1 Хөдөлмөр эрхлэлт
- 4.2 Уул уурхай
- 4.3 Газар тариалан
- 4.4 Мал аж ахуй
- 4.5 Барилга, дэд бүтэц
- 4.6 Орон сууц
- 4.7 Үйлдвэржилт
- 4.8 Төсөв, санхүү, татварын бодлого
- 4.9 Жижиг, дунд бизнес, бизнесийн дархлаа, худалдаа үйлчилгээ

Тав. Хуулийн хэрэгжилт, шударга ёс


Зургаа. Төрийн үйлчилгээ иргэдийн оролцоо

- 6.1 Төрийн албан хаагчид, төрийн үйлчилгээний шуурхай байдал

Уриа: Иргэдийн оролцоонд тулгуурласан эрчимт хөгжлийн шинэчлэл хийнэ.

Зорилго: Тунхаглалын шинжтэй иргэдийн оролцоог халж “Мэдлэг мэдээлэлтэй, чинээлэг дундаж давхаргыг бий болгох”-д оршино.

НЭГ. ИРГЭНИЙ ЭРХ, НИЙГМИЙН БАТАЛГАА



1.1 Гэр бүл, хүүхэд

- 1.1.1. Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд хүүхдээ асран хамгаалж байгаа гурав хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хүүхдээ өсгөсөн жилийн үнэлэмжийг сайжруулах саналыг холбогдох байгууллагуудад уламжилж, хамтран ажиллана.
- 1.1.2. Хүүхэд хамгаалах чиглэлийн үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.1.3. Хүүхдийн хамгааллын хариу үйлчилгээг анхан шатанд үзүүлдэг хамтарсан багт дэмжлэг үзүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын үйлчилгээний тодорхой чиглэл буюу нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх, бага насны болон хохирогч хүүхэдтэй ажиллах зэрэг мэргэшсэн дэмжих багийг бодлогоор дэмжинэ.
- 1.1.4. Монгол гэр бүлийн уламжлалт боловсролын аргад суурилсан “Зөв монгол гэр бүл- Мандалын бахархал” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 1.1.5. Нялхас болон бага насны хүүхэд, эхчүүд зорилтод бүлгийнхэнд зориулсан асаргаа, сувилгааны төвийг төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр барьж, гүйцэтгэнэ.
- 1.1.6. Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авна.

1.2 Тусгай хэрэгцээт иргэд

- 1.2.1. Тусгай хэрэгцээт иргэдийн бие даан амьдрах, нийгмийн үр дүнтэй оролцоог дэмжих, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 1.2.2. Тусгай хэрэгцээт иргэдийн сурч хөгжих, ажил хөдөлмөр эрхлэх, бие даан амьдарч, нийгмийн харилцаанд ороход нь тусалж, дэмжинэ.
- 1.2.3. Төрийн байгууллага болон банк санхүүгийн, олон нийтийн үйлчилгээний газруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан дэд бүтэц, орчин бий болгох асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.
- 1.2.4. Тусгай хэрэгцээт иргэн тогтмол орлого олох нөхцөл бололцоог хангаж, бүх талын туслалцаа үзүүлнэ.
- 1.2.5. Өндөр настан, хүүхэд болон тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан сэргээн засах сувиллын газар байгуулах эх үүсвэрийг шийдвэрлэж, хэрэгжүүлнэ.

1.3 Ахмад, эмэгтэйчүүд, залуучууд

- 1.3.1. Залуучуудын “Хөгжлийн төв”-ийг байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ.
- 1.3.2. Ахмадууд, эмэгтэйчүүд, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, үр дүнтэй хэлбэрээр

- шинэчлэн зохион байгуулна.
- 1.3.3. Холбогдох байгууллагуудтай хамтран Политехник коллежуудыг түшиглэн шинжлэх ухаан технологи, инновац, гарааны бизнес /startup/-ийн инкубатор төвийг байгуулна.
- 1.3.4. Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч, сувилагч нарыг эрүүл мэндийн байгууллагад зөвлөхөөр ажиллуулах боломжийг бүрдүүлж, бодлогоор дэмжиж ажиллана.




1.4 Боловсрол

- 1.4.1. Үндэсний эх хэл, түүх соёл, ёс заншлаа дээдлэн хөгжүүлж, түүнээс суралцан бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, насан туршдаа суралцах чадвартай, амьдрах ухаантай, ёс зүйтэй, хүмүүнлэг иргэн болгон төлөвшүүлэх зорилго бүхий “Би Монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.4.2. Байгалийн шинжлэлийн хичээлийн нэгдмэл агуулгад суурилан, шинжлэх ухааны суурь мэдлэг олгон, инженерчлэлийн чиг баримжаа олгох зорилго бүхий **/STEAM/** хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.4.3. Боловсролын салбарт хийгддэг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ЕБС, СӨБ-ын гадна, дотно орчныг шинэчлэх бодлого баримтална.
- 1.4.4. Ард иргэд, аж ахуйн нэгж, компаниуд, хандивлагчдын идэвхтэй оролцоо, дэмжлэгийг хангах замаар “Боловсролыг дэмжих сан”-г байгуулж, нээлттэй, олон нийтийн хяналттай, ил тод, үр дүнтэй зарцуулж хэвшүүлнэ.
- 1.4.5. Багшийн хөгжлийг хангасан “Сайн багшаас - хөгжсөн сурагч” сумын дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 1.4.6. Иргэдийг амьдрах ухааны сургалтад хамруулах орчин бүрдүүлэх зорилгоор “Насан туршийн боловсролын төв”-ийг байгуулах саналыг холбогдох байгууллагуудад уламжлан, шийдвэрлэнэ.
- 1.4.7. Залуу гэр бүл, залуусын нийгмийн асуудалд анхаарч, тэдний ажиллаж хөдөлмөрлөх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд 0-2 настай хүүхдийг хамруулах ясли, хүүхэд харах үйлчилгээг бодлогоор дэмжинэ.
- 1.4.8. СӨБ-н хамран сургалтыг нэмэгдүүлэхийн тулд шинээр цэцэрлэг байгуулах буюу өргөтгөх ажлыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлнэ.
- 1.4.9. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр “Багшийн хөгжлийн төв” байгуулах саналыг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 1.4.10. Багш сурагч солилцооны хөтөлбөр боловсруулж, хөгжингүй улс орнуудын боловсролын хөтөлбөр, бусад стандартуудыг нэвтрүүлэх хамтын үйл ажиллагааг хөгжүүлнэ.
- 1.4.11. Сургуулийн автобусаар үйлчилж, хүүхэд сургуульдаа аюулгүй ирж, буцах нөхцөлийг бүрдүүлж, камержуулалтыг өргөжүүлнэ.
- 1.4.12. Сургууль, цэцэрлэгийн болон дотуур байрны хүүхдийн хоолны орц норм, амт чанарт онцгойлон анхаарч эрүүл аюулгүй хоол хүнсээр үйлчилнэ.
- 1.4.13. “Хүүхдэд ээлтэй Мандалчууд” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.4.14. Тусгай хэрэгцээт болон зорилтод бүлгийн хүүхдүүд сурч хөгжих “Тэгш

боломж” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- 1.4.15. Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, тэдний санаа бодлыг мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд тусгах зорилгоор насны онцлогт тохирсон нийгмийн үйл ажиллагаанд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг дэмжиж, хүүхдийн байгууллагуудтай хамтарч ажиллана.



1.5 Эрүүл мэнд

- 1.5.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах, эмчилгээ, оношилгоог чанаржуулахын тулд шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.5.2. Өрхийн эмнэлгүүдийг хүний нөөцөөр ханган, нэгдсэн эмнэлэг болон өрхийн эмнэлгүүдийн хооронд цахим сүлжээг бий болгоно.
- 1.5.3. Сумын нэгдсэн эмнэлгийг аймаг болон 3-р шатлалын буюу төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдтэй холбогдох алсын зайн оношилгоог хөгжүүлнэ.
- 1.5.4. Түнхэл тосгоны ЭМТ-ийг түргэн тусламжийн машинаар хангана.
- 1.5.5. Ажил мэргэжлээрээ тэргүүний эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжил боловсролыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад дотоодын их дээд сургууль, ижил мэргэжлийн эмнэлгүүдэд суралцуулахыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.5.6. Халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулна.
- 1.5.7. Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээг түргэн шуурхай чанар хүртээмжтэй, ил тод, ёс зүйтэй, иргэддээ ээлтэй болгоно.
- 1.5.8. Хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулж, эрт илрүүлэлт, оношилгоонд хамрагдах давтамжийг нэмэгдүүлнэ.
- 1.5.9. Архидалт, хар тамхи, мансууруулах бодист донтох, амиа хорлолтын шалтгаан, сэтгэл зүйн өвчлөлийг эрт илрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, сайжруулахад бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.5.10. Эмийн хэрэглээ, эрүүл аюулгүй байдлын хяналтыг сайжруулахад холбогдох байгууллагатай хамтран ажиллана.
- 1.5.11. Эмийн найрлагад ордог амьтан, ургамал, эрсдэлийн нөөцийг хамгаалж, үржүүлэх, тарих үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
- 1.5.12. Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн сувиллыг байгуулна.
- 1.5.13. “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд “Элэг бүтэн Монгол”, “Эрүүл шүд”, “Умайн хүзүүний хавдаргүй монгол” болон бусад арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

1.6 Соёл урлаг, спорт

- 1.6.1. Монгол өв соёлоо эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх, соёлын өвийг тоон системд хөрвүүлэн хадгалж, олны хүртээл болгох бодлого боловсруулан хэрэгжүүлж, язгуур урлагийн наадмыг зохион байгуулж ардын авьяастнуудыг тодруулна.
- 1.6.2. Археологийн болон түүх соёлын дурсгалт газрын бүртгэл, хамгаалалтыг сайжруулна.

- 1.6.3. Мэргэжлийн урлагийн байгууллага, залуу уран бүтээлчдийн уран бүтээлээ олны хүртээл болгох, ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.6.4. Сайн дурын уран сайханчид болон урлагийн холбоодын үүсгэл санаачилгыг дэмжинэ.
- 1.6.5. Спортын олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулах, оролцоход бодлогоор дэмжинэ.
- 1.6.6. Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх Соёл спорт амралтын хүрээлэнг сайжруулан өргөтгөх санхүүжилтийг холбогдох шатны төсөвт тусгуулж, хэрэгжүүлнэ.
- 1.6.7. Нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэхийн тулд орчин үеийн стандартад нийцсэн хөл бөмбөг, хоккейн талбай байгуулах санаачилга гарган, санхүүжилтийг улс, аймгийн төсөвт тусгуулан, хэрэгжүүлнэ.
- 1.6.8. Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар сургалт, сурталчилгааг сайжруулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.6.9. Бясалгал, хийн дасгал, нийтийн бүжиг, иог, чөлөөт цагийн клубийн үйл ажиллагааг дэмжин өргөжүүлнэ.
- 1.6.10. Төрийн өмчийн оролцоо бүхий соёлын байгууллагуудад менежментийн шинэчлэл хийж, бие даасан байдлыг сайжруулна.
- 1.6.11. Чөлөөт өрсөлдөөний зарчимд нийцүүлэн мэргэжлийн соёл, урлагийн байгууллагуудад нэмэлт орлого олох боломж, нөхцөлийг бүрдүүлэх талаар хамтарч ажиллана.

ХОЁР. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

- 2.1. Ардчиллын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, бүх шатны сонгуульд саналаа өгөх, Улсын Их Хуралд сонгогдсон гишүүд, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон төлөөлөгчдөөр дамжуулан саналаа илэрхийлэхийг дэмжиж ажиллана.
- 2.2. Хүний заяагдмал эрхийг хамгаалах, иргэдэд хүний эрхийн талаар ойлголт өгөх, сурталчлан таниулах үйл ажиллагааг дэмжинэ.


ГУРАВ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

- 3.1. Сумандаа орон нутгийн телевиз байгуулах санал санаачилгыг дэмжиж ажиллана.

ДӨРӨВ. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

4.1 Хөдөлмөр эрхлэлт

- 4.1.1. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шууд худалдаалах төвийг байгуулах, борлуулалтын сүлжээг бий болгох асуудлыг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.
- 4.1.2. Салбарын тогтвортой хөгжлийг хангахад шаардлагатай мэдээллийн сан бүхий мэдээллийн системийг бий болгоно.
- 4.1.3. Баялаг бүтээгчдээ дэмжиж, Мандал сумын иргэдийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- 
- 4.1.4. “Өрх бүр баялаг бүтээгч” дэд хөтөлбөрийг Мандал сумандаа үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 4.1.5. Нийслэл хот, аймаг, сумуудын бизнес хөгжүүлэх төвөөр дамжуулан бизнес эрхлэгчдийг дэмжинэ.
- 4.1.6. Иргэдийг орон сууцжуулах дэд хөтөлбөр хэрэгжүүлэх замаар барилгын салбарт ажиллагсдыг бодлогоор дэмжинэ.
- 4.1.7. Сумын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
- 4.1.8. Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлтийн судалгааны чанарыг сайжруулж, хэрэгцээтэй байгаа ажил, мэргэжлийг эдийн засгийн салбар, ажил мэргэжлээр нарийвчлан гаргаж, их дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын элсэлттэй нягт уялдуулна.
- 4.1.9. Мандал сумын хэмжээнд ядуурлын түвшнийг улсын дунджаас бууруулах үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.1.10. Эрдэс баялаг, малын гаралтай түүхий эдийг боловсруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.


4.2 Уул уурхай

- 4.2.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлд түшиглэн ашигт малтмалыг олборлож, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох боломжтой үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих бодлого баримтална.
- 4.2.2. Хариуцлагатай уул уурхайн олон улсын стандарт, шалгуур үзүүлэлтүүдийг иргэн, аж ахуйн нэгж бүр үйл ажиллагаандаа хатуу мөрдөж, ашигласан болон ашиглаж байгаа талбайг хамгаалах, нөхөн сэргээлтийг заавал хийж байх ажлыг хэвшил болгон тогтмолжуулна.
- 4.2.3. Аюулгүй ажиллагааны хариуцлагыг чангатган уул уурхайн хайгуул болон олборлолт, хаалтын аюулгүйн үйл ажиллагааг зохицуулах хууль журмыг хэрэгжүүлнэ.
- 4.2.4. Мандал сумын нутаг дэвсгэрт нөхөн сэргээх шаардлагатай газруудад иргэн, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоо, олон улсын байгууллагуудтай хамтран ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.2.5. Сумын “Уул уурхайн талаар баримтлах бодлого”-ын хүрээнд бичил уурхай эрхлэгчдийг бизнесийн бусад салбарт шилжин ажиллахад нь бодлогоор дэмжинэ.
- 4.2.6. Бичил уурхайн эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал хүргүүлж, шаардлага хангасан зарим нөхөрлөл, хоршоог уул уурхайн олборлолтын аж ахуйн нэгж хэлбэрээр албажуулан хууль бус олборлогчдод тавих төрийн хяналтыг сайжруулна.
- 4.2.7. Уурхайн үйл ажиллагааны хяналт, нөхөн сэргээлт, хаалтын стандартыг олон улсын жишигт хүргэж, дүйцүүлсэн нөхөн сэргээлтийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулна.
- 4.2.8. Мандал суманд ашиглалтын лиценз эзэмшиж буй уул уурхайн ашиглалт, нийгмийн хариуцлагад тавих хяналтыг өндөржүүлж, орон нутаг дахь үр өгөөжийг дээшлүүлнэ.

4.3 Газар тариалан

- 4.3.1. Усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн ус, эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй техник, технологийн хангамжийг сайжруулж, нэгжээс авах ургацыг дээшлүүлнэ.
- 4.3.2. Хүлэмжийн аж ахуй, дуслын усалгаанд шаардлагатай нар, салхины сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах төсөл хэрэгжүүлнэ.
- 4.3.3. Өрх, байгууллага бүр хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, шинэ ногооны нэр төрөл, хангамжийг сайжруулна.
- 4.3.4. Газар тариалангийн бүс нутаг болох Мандал суманд услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг дэмжинэ.
- 4.3.5. Газар тариалангийн салбарыг хөгжүүлэх бодлогын хүрээнд үрийн аж ахуйн системийг боловсронгуй болгож, хөрс, цаг уурын онцлогт тохирсон, баталгаат сортын үрийн хангамжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 4.3.6. Үр тариа болон ургамал хамгаалах химийн бодис, бордоо, био бэлдмэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.
- 4.3.7. Өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг газар тариалангийн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлнэ.
- 4.3.8. Ургамал хамгаалалтын орчин үеийн арга технологийг иж бүрэн хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, хортон шавжаас хамгаалах, үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 4.3.9. Дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.
- 4.3.10. Жимс, жимсгэнийн дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 4.3.11. Газар тариалангийн үйлдвэрлэлийн мэргэжлийн ажиллах хүчний хангамж, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 4.3.12. Мандал суманд хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлж, "Органик хүнс" хөтөлбөр боловсруулж, мах, сүү, гурил, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг ханган, экспортлох бодлого баримтална.
- 4.3.13. Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын хүнсний бүтээгдэхүүний лаборатори байгуулахыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 4.3.14. Мэдээллийн технологийг ашиглан мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.
- 4.3.15. Бүх нийтийн хүнсний боловсролыг дээшлүүлэх, хоол хүнс, шим тэжээлийн чанар, аюулгүй байдлыг эрүүл амьдралын зан үйл, хэвшилтэй нягт уялдуулах чиглэлээр сумын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.3.16. Төмс хүнсний ногоо, сүү сүүн бүтээгдэхүүнээр хүртээмжтэй хангаж, дотоодын зах зээлийн хүнсний нийлүүлэлтийн сүлжээг бий болгож, аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлэх замаар "Найдвартай хүнс нийлүүлэгч сум" болох бодлого баримтална.
- 4.3.17. Малчдын малаа маллах дундын бэлчээрийг баталгаажуулж, ашиглалтын хариуцлагыг нэмэгдүүлж, малчдын эрх ашгийг хамгаална.

- 4.3.18. Суурин болон хагас суурин маллагаатай эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх журам, зохицуулалтын бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 4.3.19. Тариалангийн талбайд ойн зурвас байгуулж, хөрсний элэгдэл, малын хөлөөс хамгаална.
- 4.3.20. Газар тариалангийн үйлдвэрлэлд техникийн шинэчлэл хийж, баталгаат сортын үрийн хангамж, ургамал хөрс хамгаалалт, услалтын систем барих зэрэг агротехникийн цогц арга хэмжээг дэмжинэ.




4.4 Мал аж ахуй

- 4.4.1. Малыг эмч нарын ур чадварыг дэмжих замаар нэгж малд ноогдох мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулна.
- 4.4.2. Мал эмнэлгийн байгууллагын санаачилгад үндэслэн “Малын эмчилгээ, сувилгааны төв”-ийг төв, суурин газраас зайтай, бэлчээрийн бүс нутагт малчдад ойрхон байгуулах санаачилгыг дэмжинэ.
- 4.4.3. Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийн 30-аас доошгүй хувийг сэргээнэ.
- 4.4.4. Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэх мэдлэг бүхий малчдыг малчин бизнесмен болгох замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.4.5. Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг хөгжүүлнэ.
- 4.4.6. Малыг гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх хяналтыг сайжруулж, малыг вакцин, туулгад бүрэн хамруулж, эрүүлжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.4.7. Малаас гарч буй түүхий эд болох арьс шир, ноос ноолуурыг боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 4.4.8. Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгий, загасны аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загварыг хөгжүүлнэ.

4.5.Барилга, дэд бүтэц

- 4.5.1. Бага, дунд орлоготой иргэдэд зориулж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сумын ерөнхий төлөвлөгөө, зураг төслийг иргэдийн оролцоонд тулгуурлан боловсруулж, дэд бүтэцжүүлэх ажлыг хамтран хэрэгжүүлнэ.
- 4.5.2. Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр өгөөжтэй, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан шинэ технологийн халаалт, дэд бүтцийн систем нэвтрүүлэх ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 4.5.3. Нийтийн орон сууцны ашиглалтын хүрээнд төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн төрийн бус байгууллага болон СӨХ-ийн түншлэлд шилжүүлэх журмаар засвар, үйлчилгээний, инженерийн хангамжийн асуудлуудыг өмчлөгч өөрөө хариуцах чадамжийг бэхжүүлж, төрийн оролцоог хязгаарлах бодлого хэрэгжүүлнэ.

- 
- 4.5.4. Амины орон сууцны болон хуучин орон сууцны дулаан алдагдлыг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.
 - 4.5.5. Гэр хорооллын дэд бүтцийг шийдэж, айл бүрийг хашаандаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Таны хашаа” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
 - 4.5.6. Барилга, байгууламжийн насжилтыг тогтоож мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, дахин төлөвлөх ажлыг эхлүүлнэ.
 - 4.5.7. Гудамж, нийтийн эзэмшлийн талбай, авто замуудыг камержуулах ажлыг үргэлжлүүлнэ.
 - 4.5.8. Шинэ суурьшлын бүс болон сумын төвийн шинэчлэлийн хүрээнд инженерийн шугам сүлжээ, дэд бүтэцтэй барилга байгууламжийг барих ажлыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэнэ.
 - 4.5.9. Хотжилтыг дэмжих зорилгоор Мандал суманд барилгын материалын жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодлогоор дэмжинэ.
 - 4.5.10. Эдийн засгийн өсөлтийн суурь болсон дэд бүтэц /зам тээвэр, эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, усан хангамж, мэдээлэл, харилцаа холбоо/ -н хөрөнгө оруулалтыг хувийн, төсвийн, болон төр хувийн хэвшлийн түншлэл зэрэг санхүүжилтийн бүхий л төрөл, боломжийг идэвхтэй ашиглана.
 - 4.5.11. Мандал суманд “Гудамж” төслийг үргэлжлүүлэн, авто замын уулзварыг шинэчлэх ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бодлого баримтална.
 - 4.5.12. Хүн амыг эрүүл ахуй, чанарын шаардлагад нийцсэн усаар хангаж, дэд бүтцийг сайжруулна.
 - 4.5.13. Сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг барих төр хувийн хэвшлийн түншлэлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
 - 4.5.14. Үерийн нэгдсэн далангийн зураг төсөл хийлгэж, үе шаттайгаар бүтээн байгуулж, иргэдийг гамшгаас хамгаалах, орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 4.5.15. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх дулааны цахилгаан станц байгуулах, дулаанаар хангах ажлыг дэмжиж ажиллана.
 - 4.5.16. Гэр хорооллын гудамж, замуудыг асфальт болон бетонон зам болгох ажлыг үргэлжлүүлэн шат дараатай хийж гүйцэтгэнэ.
 - 4.5.17. Төмөр замын гармуудыг стандарт шаардлагад нийцүүлж сайжруулах талаар мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.
 - 4.5.18. Замын ачааллыг бууруулах бодлого боловсруулж ажиллана.
 - 4.5.19. Автомашины туслах замуудыг стандартын шаардлагад нийцүүлж сайжруулна.
 - 4.5.20. Ерөнхий боловсролын 5-р сургуулийн спорт заалны барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
 - 4.5.21. Тоосгоны болон төмрийн үйлдвэрийг сумын төвөөс гаргах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
 - 4.5.22. Гудамж талбайн гэрэлтүүлгийг сайжруулах ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.
 - 4.5.23. Ногоон байр, чулуун байрны айлуудын газрыг иргэнд өмчлүүлэх асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
 - 4.5.24. Түнхэлд Онцгой байдлын тасаг бий болгох талаар холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

4.5.25. Хогийн нэгдсэн цэгийг нүүлгэн шилжүүлж, хогны менежментэд олон улсын туршлагыг нэвтрүүлнэ.

4.6 Орон сууц

4.6.1. “Тогтвортой орлого бүхий орон сууц” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, 20-100 айлын орон сууцыг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн байршилтай уялдуулан хүн амын зорилтот бүлэгт тааламжтай нөхцөлөөр бүтээн байгуулах хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжинэ.

4.7 Үйлдвэржилт

- 4.7.1. Орон нутагт өрсөлдөх чадвар бүхий түүхий эд, эрдэс баялгийг боловсруулах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин ажиллана.
- 4.7.2. Хөдөө аж ахуйн боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, олон улсын чанар, стандартыг нутагшуулж, экспортлох цогц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх талаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 4.7.3. Орон нутагтаа стратегийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл явуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжинэ.
- 4.7.4. Загас, загасан бүтээгдэхүүн нөөшлөх үйлдвэрийг барьж байгуулах хувийн хэвшил, иргэдийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.
- 4.7.5. Импортын хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулахад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 4.7.6. Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг чанартай хүнсээр хүртээмжтэй хангаж, дотоод зах зээл дэх хүнсний нийлүүлэлтийн сүлжээг бий болгож аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлэх замаар найдвартай хүнс нийлүүлэгч сум болно.
- 4.7.7. Үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг гаднын байгууллагуудын хөрөнгө оруулалт, зээл, тусламжид хамруулах бодлого баримтална.
- 4.7.8. Төрөөс аж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхэд баримтлах бодлогын хүрээнд орон нутагтаа томоохон үйлдвэрлэлийн төслүүдийг эхлүүлнэ.
- 4.7.9. Байгалийн болон бэлчээрийн мал аж ахуйн гаралтай органик хүнс, хүнсний нэмэлт тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжиж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.

4.8 Төсөв, санхүү, татварын бодлого

- 4.8.1. Орон нутгийн төсвийн зардлыг ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэх зарчимд шилжиж, үр ашигтай хуваарилалтын бодлого хэрэгжүүлнэ.
- 4.8.2. Орон нутгийн үйлдвэрлэгчдийнхээ бүтээгдэхүүнийг худалдан авах хандлагыг бий болгож мөнгөн гүйлгээг нутагтаа авч үлдэх бодлого баримтална.
- 4.8.3. Хуримтлалыг бий болгох сургалт мэдээллийн бодлогыг хэрэгжүүлж иргэдийн банкин дахь хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.8.4. Татварын байцаагч, иргэн, аж ахуй нэгж, байгууллагын харилцан уялдаа холбоог сайжруулан, татварын зөвлөгөө өгдөг, хуулийг дээдэлдэг, бизнесийг дэмждэг чиглэлийг баримтална.

- 4.8.5. Иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн өгөөжтэй санхүүгийн зуучлалыг хөгжүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.
- 4.8.6. Үнэт цаасны брокерын үйл ажиллагааг тогтвортой ажиллуулахыг дэмжинэ.
- 4.8.7. Малын тоо толгойн албан татварыг бууруулах нөхцөл, боломжийг судалж, шийдвэрлэх арга хэмжээ авна.

4.9 Жижиг, дунд бизнес, бизнесийн дархлаа, худалдаа үйлчилгээ

- 4.9.1. Жижиг, дунд, бичил үйлдвэрлэл эрхлэгчдийн зах зээлийг тэлэх, нийслэл хот болон бусад аймаг сумдын худалдаанд идэвхтэй оролцоход нь бодлогоор дэмжиж ажиллана.
- 4.9.2. “Хоршоог хөгжүүлэх сан”-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, экспортын үйлдвэрлэлийг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.9.3. Жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, гарцыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийн сан үүсгэж, гарааны бизнесийг бодлогоор дэмжин, бүтээгдэхүүн үйлчилгээг мэдээллийн санд байршуулна.
- 4.9.4. Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал, дарамтыг арилгаж, татвар төлөгч аж ахуй нэгжүүддээ үйлчилдэг, зөвлөдөг болгоно.
- 4.9.5. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.
- 4.9.6. “Хоршоог хөгжүүлэх сан”-аас санхүүжүүлэх бизнес, төсөл, арга хэмжээний жагсаалтыг шинэчилж, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, нийгмийн зорилтот бүлгийг харгалзан үздэг зарчмыг баримтална.
- 4.9.7. Хүн амын хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээг аюулгүй, чанартай хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлийг баримтална.
- 4.9.8. Хүн амын хүнсний чанар, шим тэжээлийг сайжруулж, тэнцвэртэй, эрүүл хооллолтын зохистой дадлыг хэвшүүлнэ.
- 4.9.9. Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааны орчныг либералчилж, эко, ногоон, органик шошготой бүтээгдэхүүнийг олшруулан сав баглаа, боодлыг нэгдмэл стандарттай болгоно.
- 4.9.10. Хот, суурин газрын хүнсний нийтийн хэрэглээний малыг зөвхөн үйлдвэрийн аргаар нядалж боловсруулах стандартыг бүрдүүлж, энэ чиглэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 4.9.11. Хүнсний аюулгүй байдлын найдвартай статистик мэдээллийн системийг нэвтрүүлж, хүнсний бүтээгдэхүүний хяналтын тогтолцоог шинэчилнэ.
- 4.9.12. Хүнсний гол хэрэгцээ болох мах, ногооны зориулалтын зоорийг барих, мах, хүнсний ногооны хадгалалтыг сайжруулах асуудлыг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 4.9.13. Хүнсний захад баримталдаг ариун цэвэр, аюулгүй байдлын стандартыг шинэчилж, чанд мөрдүүлнэ.
- 4.9.14. Суурь хэрэгцээний хүнсийг дотооддоо үйлдвэрлэх аж ахуйн нэгжүүдийн санал, санаачилгыг дэмжинэ.
- 4.9.15. Мэдлэг, технологийн дэвшил, инновац шингэсэн орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжин өрсөлдөх чадварыг сайжруулж, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

- 4.9.16. Жимс, жимсгэнэ, нарийн ногоо тариалах болон хүлэмжийн газар олгох, ашиглахад уян хатан бодлого баримталж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

ТАВ. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ШУДАРГА ЁС

- 5.1. Хууль, шүүхийн байгууллагын албан хаагчдын ёс зүй, зан харилцаанд иргэд олон нийтийн хяналтыг бий болгох бодлогыг хамтран хэрэгжүүлнэ.
- 5.2. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисоос хамааралтай, донтогч болсон иргэнд эмнэлгийн, сэтгэл зүйн болон нийгмийн тусламж, үйлчилгээ үзүүлэх бодлого баримтална.
- 5.3. Үзэл бодол, яс үндэс, нас, хүйс, хөгжлийн ялгаа, бэлгийн чиг баримжаа гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг гэр бүлийн орчин, ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.4. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 5.5. Нийтэд тустай хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг нэмэгдүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, хүртээмжийг сайжруулах бодлого баримтална.
- 5.6. Гамшиг, аюулаас хамгаалах мэргэжлийн байгууллага болон орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, хамтарч ажиллана.
- 5.7. Сумын нутгийн удирдлагын байгууллагын ил тод, нээлттэй байдал шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор цахим ИТХ-ыг жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.
- 5.8. Иргэд гарын үсэг цуглуулж, тодорхой асуудлыг хөндөж дэвшүүлсэн тохиолдолд аймаг, сумын ИТХ шууд авч хэлэлцэх боломжийг судлан, холбогдох байгууллагатай хамтран ажиллана.
- 5.9. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэнэ.
- 5.10. Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчимд тулгуурласан нутгийн удирдлагыг бэхжүүлнэ.
- 5.11. Төсвийн зарцуулалт, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- 5.12. Орон нутагт хэрэгжүүлэх аливаа төсөл, хөтөлбөр, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтийн оролцоотой ил тод, нээлттэй болгоно.

ЗУРГАА. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

6.1.Төрийн албан хаагчид, төрийн үйлчилгээний шуурхай байдал

- 6.1.1. Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч буй иргэд жижиг, дунд, бичил бизнесийн салбарт ажиллах, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ.
- 6.1.2. Бүх шатны төрийн албан хаагчдыг эрхэлдэг ажлынхаа чиглэлээр сурч боловсрохыг дэмжиж, жил бүр сургалтад хамруулна.
- 6.1.3. Сумандаа засаглалын зөв механизмыг бүрдүүлж, мөчлөг дагасан

- сонгуулийн бодлогоос татгалзаж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, төрийн албаны мерит зарчмыг баримтална.
- 6.1.4. Засаглалын эрүүл орчныг бий болгож, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын итгэл, сонирхол татах орчныг бүрдүүлэх бодлого баримтална.
- 6.1.5. Орон нутгийн хөгжлийн ялгааг арилгаж, тэнцвэртэй хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ.
- 6.1.6. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, ~~мэргэжлийн холбоод~~, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.
- 6.1.7. Төрийн албан хаагчдын ангилал, зэрэглэл, ажлын байранд тавигдах шалгуур, шаардлагыг тодорхой болгож, нам дагасан томилгооноос салгана.
- 6.1.8. Төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, иргэний оролцоот үнэлгээ, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлнэ.
- 6.1.9. ИТХ-ын дэргэдэх өргөдөл, гомдлыг хүлээж авах хорооны үйл ажиллагааг сайжруулж, цахим хэлбэрт шилжүүлнэ.
- 6.1.10. Төрийн албаны мерит зарчмыг хадгална.

МАНДАЛ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО